

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЭЦСИЙН
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН, БАЙНГЫН ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 05 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлсэн.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан явуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран иргэдэд танилцуулж санал авах арга хэмжээ нь төслийн I, II, III зэрэглэлийн алинд хамаарч байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар хууль батлагдсаны дараа хууль сурталчлах ажлыг хэрхэн зохион байгуулах, гомдол барагдуулах механизмыг бүрдүүлсэн эсэх, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ ерөнхий шинжээч, шинжээчид тавигдах шаардлагад өөрчлөлт орсноор ямар эерэг, сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж хуульд заасан журмыг хуулийн хугацаанд чанартай боловсруулах талаар асуулт асууж, үг хэлсэн болно.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг нэгдсэн хуралдаанаар явуулах үед хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн 3, нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн 1 саналын томъёоллоор тус бүр санал хураахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.


Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хувилбар болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Б.БЕЙСЕН

Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт
2026.05.13.

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААР БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН
ТОМЬЁОЛОЛ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн
хураалгасан санал:

1.Төслийн 3 дугаар зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах ерөнхий шинжээч, шинжээчийн эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

7.6.1.ерөнхий шинжээч нь байгаль орчны чиглэлээр 8-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байх;

7.6.2.шинжээч нь байгаль орчны чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх мэргэжлийн чадвар, ажлын туршлагатай байна.”

**Санал гаргасан: Байгаль орчин, хүнс,
хөдөө аж ахуйн байнгын хороо**

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалт буюу 7 дугаар зүйлийн 7.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.13.Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны ерөнхий үнэлгээнд санал авах хүсэлтийг төслийн товч танилцуулга, газрын эрхтэй холбоотой баримт бичгийн хамт тухайн сум, дүүргийн Засаг даргад гаргана.”

**Санал гаргасан: Байгаль орчин, хүнс,
хөдөө аж ахуйн байнгын хороо**

3.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд танилцуулж, санал авах бөгөөд баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын даргад хүсэлт илгээснээс хойш 30 хоногийн дотор уг асуудлаар хурал хуралдсан тохиолдолд тайланг танилцуулж, санал авах ажлыг зохион байгуулна.”

**Санал гаргасан: Байгаль орчин, хүнс,
хөдөө аж ахуйн байнгын хороо**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай
хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтыг үндэслэн
хураалгасан санал:

1.Төслийн 3 дугаар зүйлийн 9 заалт буюу 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.4.Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Байгаль орчныг хамгаалах тухай, Усны тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, энэ хуулийн 10.5-д заасан танилцуулгаас гарсан саналыг тусгасан байдал, нарийвчилсан үнэлгээний тайланд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээч, мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.”

**Санал гаргасан: Байгаль орчин, хүнс,
хөдөө аж ахуйн байнгын хороо**